



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.03.20 № 15-134-12/1152

танай _____-ны № _____-т

Тодруулгад хариу өгөх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан Багц-№2 “Олон улсын стандартын шаардлага хангасан лабораторийн барилгын тоног төхөөрөмж нийлүүлж угсарч суурилуулах, туршилт тохируулга хийх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/202401011290 дугаартай тендерт оролцогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

612407006074

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны 03 дугаар
сарын 20 өдрийн 75-134-12/1152 дугаартай албан
бичгийн хавсралт



ЭҮТӨҮГ/202401011290 дугаартай “Олон улсын стандартын шаардлага хангасан лабораторийн барилгын тоног төхөөрөмж нийлүүлж угсарч суурилуулах, туршилт тохируулга хийх ажил”-ын тендер

1. ЛАБОРАТОРИЙН СОРИЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ ТАВИЛГАТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА:

Хавсралт № 53 ба 54-т заагдсан шинжилгээний ширээ нь доороо шүүгээ, дээрээ полкотой байх ба хэмжээний хувьд барилга угсралтын явцад тоног төхөөрөмж, ажлын зай, барилгын хэмжээнээс хамаарч өөрчлөгдөх боломжтой. Иймд барилга угсралтын явцад захиалагч ба нийлүүлэгч хамтран гаргаж үйлдвэрлэгдэнэ.

Хүснэгт дэх 14 заагдсан хөдөлгөөнт татах шүүгээ нь химийн бодист тэсвэртэй нэржэн эсвэл хуванцар байх ба Олон улсын англи нэршлээр laboratory arm hood гэж нэрлэгддэг. Хэмжээний хувьд барилга угсралтын явцад тоног төхөөрөмж, ажлын зайнаас хамаарч захиалгаар үйлдвэрлэгдэнэ.



Хүснэгт дэх 15, 16-д заагдсан тоног төхөөрөмжийн тавиур болон шатаах зуухын тавиурууд химийн бодист тэсвэртэй нэрж материалаар хийгдэж, хүнд жингийн тоног төхөөрөмжүүдийг даах даацтай байх ба 650 градус цельсээс 1100 градус цельсэд тэсвэртэй байхаар үйлдвэрлэгдэнэ. Хэмжээний хувьд суурилагдах тоног төхөөрөмжөөс хамаарч барилга угсралтын явцад захиалагч талтай хамтарч гаргана.

Хүснэгт 8-14 заасан хэмжээтэй татах шүүгээнүүдийг Waldner эсвэл түүнтэй дүйцэхүйц үйлдвэрлэгч компанид барилга угсралтын явцад захиалгаар үйлдвэрлүүлэх боломжтой. Нийлүүлэгч компани татах шүүгээ бүрийг угсарч ажилд оруулан хүлээлгэж өгнө гэдгийг анхаарна уу.

2. ОФФИС ТАВИЛГА ЭД ХОГШИЛТОЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА:

Шинэ барилгад суурилагдах оффис тавилгууд нь зураг төсөлд тусгагдсан хэмжээгээр буюу барилга угсралтын явцад өөрчлөгдөх эрсдэлтэй байгаа тул барилга угсралтын явцад нарийвчилсан техникийн тодорхойлолтыг захиалагч болон гүйцэтгэгч тал хамтарч гаргах шаардлагатай.

Тухайн төсөлт ажил нь бараа нийлүүлэхээс гадна олон улсын стандартын шаардлага хангасан лабораторийн цогцолборыг бүтээн байгуулахад барилга угсралтын компанитай хамтран ажлын уялдаа холбоог гаргаж ажиллана гэдгийн анхааруулъя.

3. ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОДРУУЛГА:

Malvern Panalytical ZETIUM Spectrometer спектрометр нь шингэн ба хатуу дээжид шинжилгээ хийх тул тендерийн баримт бичигт заагдсан техникийн тодорхойлолтын дагуу тохиргоог хийнэ.

4. ХАВСРАЛТ 9:

LC/MS спектрометрийн иж бүрдлийн жагсаалт 25-д заагдсан шинжилгээний стандарт уусмал болон стандарт загвар дээжүүдийг багаж нийлүүлэгдэх үед сорилт, шинжилгээний аргын төрлөөс хамаарч сонголт хийнэ.

5. ХАВСРАЛТ 14.

Элементийн шинжилгээний XRF спектрометрийн иж бүрдэл (дээж бэлтгэл болон дагалдах иж бүрдлийн хамт) гэдэгт дээжийг зууханд хайлуулж, шилэн бэлдэц гаргаж авахад зориулагдсан тигель 6 ширхэг байх ёстой болон ХАВСРАЛТ 15-т бичигдсэн XRF дээж задаргааны шилэн бэлдцийн зуухны иж бүрдлийн тухай бичигдсэн гэж ойлгоно.

6. ХАВСРАЛТ 16.

Рентген дифрактометрийн иж бүрдэлд техникийн тодорхойлолтын 69 дүгээр хуудсанд бичигдсэн 35 нэр төрлийн бэлбэг материалын жагсаалт болон ХАВСРАЛТ 17-д заагдсан дээж бэлтгэлийн төхөөрөмж багтана. Нийлүүлэгч тал багажийг бүрэн ажилд оруулж, хүлээлгэн өгнө гэдгийн анхаарна уу.

7. ХАВСРАЛТ 43.

Лабораторийн зориулалттай Мөнгөн усны анализаторын иж бүрдэлд тухайн бүрэн хүчин чадлаар буюу хүнсний бүтээгдэхүүн, төрөл бүрийн ус, хүдэр, зэс-молибдений баяжмалд мөнгөн ус тодорхойлоход шаардлагатай сэлбэг хэрэгслийг багаж үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу гаргаж нийлүүлнэ.

БОЛОВСРУУЛСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ХИМИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ

Цахим

Б.АНХЗАЯА